

“БҮТЭЭЛЧ-ҮЙЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД КОМПАНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.ЭРДЭНЭБИЛЭГИЙН ТАВЬСАН ТАЙЛАН

2015.04.22

Налайх дүүрэг

Компаний 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жилийн эцсийн санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2014 онд хийсэн ажил, цаашид тавих зорилтын талаар.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая, Та бүхэн ажил албаа зохицуулан хурлаа хүндэтгэн ирсэнд баярлалаа.

Би тус компанийг удирдах болоод удаагүй байна. Оёдлын үйлдвэр нь гар ажиллагаа ихтэй, ашиг багатай, нийгмийн халамж хамгаалал их шаарддаг салбар юм. Энэ үйлдвэр нь 2013 оноос сурагчийн форм, ажлын хувцас оёх болж нилээд том зах зээлийн сэжүүрээс барьж авсан юм. Энэ зах зээлээ алдахгүйн төлөө чармайн ажиллаж байна. Тус үйлдвэр нь “Шилмэл загвар”, “Өүлэн менч”, “Торгон хийц”, “Эрд сүлж” ХХК-уудтай хамтран сурагчийн дүрэмт хувцсыг кластерийн системээр оёх төсөл боловсруулан хэрэгжүүлж өнгөрсөн хугацаанд 94,000 хос хувцас оёж нийслэл болон хөдөө орон нутагт хүргэсэн байна.

Одоо 2014 оны ажлын үр дүнгийн талаар 2014 оны санхүүгийн тайлан түүнд “Акпар аудит” ХХК-ын өгсөн дүгнэлтийг үндэслэн товч мэдээлэл хийн 2014 онд 470428,3 мянган төгрөгийн борлуулалт хийж, өртөг 344919,6 мянган төгрөг ерөнхий ба удирдлагын зардал 34842,3 мянган төгрөг байв.

Ажилчдад 36760,6 мянган төгрөг олгож, нийгмийн даатгалд 8354,9 мянган төгрөг төлсөн. 101858,6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан бол ашиглалтын зардал, түлш шатахуун тээврийн хэрэгслэлд 27495,8 мянган төгрөг зарцуулсан байна.

2014 онд 532725,2 мянган төгрөгийн зээл авч зээл, зээлийн хүүд 1064161,2 мянган төгрөг төлжээ. Мөн хугацаанд татварын байгууллагад 21389,1 мянган төгрөг төлсөн байна.

2025590,2 мянган төгрөгийн бараа материалтай, 282619,0 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, авлага 2351,7 мянган төгрөг, 1628003,8 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй, 811378,9 мянган төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй ажиллаж иржээ.

Үйлдвэрийн өөрийн хөрөнгө 168283,0 мянган төгрөг нь 100% хувийн өмч юм. Бусад дэлгэрэнгүй мэдээллийг 2014 оны санхүүгийн тайлан, түүний тодруулгаас авч болно.

Одоо үйлдвэрийн өмнө тулгарч байгаа асуудал, цаашдын зорилтын талаар ярья.

Юуны өмнө үйлдвэрийн барилгын их засвар хийх асуудлыг дэвшүүлсэн. 1-р сарын ТУЗ-ийн хурал дээр энэ асуудлыг оруулсан. Үүнийг дэмжсэн ТУЗ-ийн тогтоол гаргаж өгөөрэй гэдгийг энэ далимд хүсч байна. 2015 оны 2-р сараас эхлэн үйлдвэрийн барилгын их засварыг эхлүүлсэн одоо ажлын явц 60%-тай байна. Их засварт 415 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд одоогоор 30 сая төгрөг зарцуулаад байна. Мөн үйлдвэрийн цаашдын ажлын талаар төлөвлөгөө гаргаад ажиллаж байна.

2015 оны 4 сараас зарим нэг ажлын хувцасны болон дүрэмт хувцасны захиалга авч эхний ээлжинд 50 ажлын байр бий болгон ажил эхлүүлээд байна. Цаашид ажиллагсадын тоог 120 хүргэх төлөвлөгөө гаргасан. Үйлдвэр маань бүрэн хүчин чадлаараа ажиллавал сард 100 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой юм.

Үүний тулд юуны өмнө ажлын зохион байгуулалт, цаг ашиглалтыг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авлаа. Ажилчдын ирцийг хурууны хээгээр бүртгэх, тасаг цех болон үйлдвэрийн гадна талыг камержуулах ажлыг хийлээ. Удирдах ажилтан нарын бүрэлдэхүүнийг өөрчлөн шинээр хүний нөөцийн менежерийн

орон тоог бий болгов.Ажлын туршлага ихтэй ахмад оёдолчид Налайх дүүрэгт олон байдаг нь сайшаалтай, ажилд дэмжлэгтэй зүйл юм.

Цаашид ажилчдынхаа ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтыг үйлдвэр дээрээ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.

Тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах зорилгоор хэвлэгч машин 2ш, программ бүхий оёдлын машин 40 ширхэг, зэрэг 80 сая төгрөгийн тоног төхөөрөмж авахаар төлөвлөөд байна.

Ажлын болон дүрэмт хувцасны захиалга өгөх байгууллагын тоог олшруулах, захиалгын хэмжээг өсгөх бүх талын арга хэмжээ авч ажиллах болно.Энд ТУЗ-ийн болон захиргааны ажилтны идэвхи чармайлт их үүрэг гүйцэтгэнэ шүү. Ажлын хуучин арга барилаасаа салж шинээр сэтгэж, шинээр ажиллах өндөр шаардлага тавьж ажиллана.

Компаний дүрэмтэй танилцаж байна: Энэ удаа компаний дүрэмд өөрчлөлт оруулах санал тавихгүй. Шаардлагатай бол дараагийн хуралд санал оруулна. Мөн Н.Энхболдын нэр дээрх хувьцааны 20%-ыг Д.Эрдэнэбилэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

Оёмол бүтээгдэхүүний зах зээл хомс, материалын олдоц муу, захиалгат хувцасны тоо цөөн зэрэг нь тус үйлдвэрийн ажилд сөргөөр нөлөөлж байна. Мөн валютын ханш өндөр байгаа нь гаднаас тоног төхөөрөмж, барилгын материал авахад хүндрэл учруулдаг.

Бид 2010-2012 оны хүнд үеийг даван туулж хөл дээрээ босох үедээ ороод байна. Энэ боломжийг алдаж болохгүй. Ажлын өндөр бүтээмжтэй, хамгийн өндөр үр ашигтай, тэргүүний оёдлын үйлдвэр болохын төлөө хамтран ажиллацгаая.

Та бүхийг хүндэтгэсэн Д.Эрдэнэбилэг